



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/46

Бор-Өндөр

**Боловсролын байгууллагуудад агуулахын  
тооллого зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, Хэнтий аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын Боловсролын байгууллагуудад агуулахын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Оюунтуяа

Төсөв, төрийн сан хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Эсүжин

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүн:

Ц.Баярхүү

Цагдаагийн хэлтсийн Хэсгийн байцаагч

П.Адилжаргал

1 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Г.Энхсаруул

2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Д.Гэрэлмаа

3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Ц.Ганхүү

БӨЦСургуулийн захирал

Ч.Амаржаргал

Бор-Өндөр бага сургуулийн захирал

О.Гибрат

Мэргэжлийн боловсролын сургуулийн захирал

2. Агуулахын тооллогын ажлыг хууль, тогтоомж, заавар журмын дагуу зохион байгуулж, дүн, тайлан мэдээг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сумын тооллогын ажлын хэсэгт хүргүүлэхийг боловсролын байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Агуулахын тооллогыг хууль тогтоомж, заавар, журмын дагуу төлөвлөгөө гарган, боловсролын байгууллагуудыг хамруулан зохион байгуулж, дүн, тайлан мэдээг хугацаанд нь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ